

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ /төсөл/

2024 оны 05 сарын өдөр

Дугаар

Мандалговь

“Тариф шинэчлэн батлах тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 дугаар "Аргачлал батлах тухай" тушаалын 2 дугаар хавсралт “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлал”-ын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт мөрдөх нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх зардал, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифуудыг 1 дүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Тогтоолыг холбогдох баримт бичгийн хамт Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлэхийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга (Ш.Энхсүх)-д даалгасугай.

3. Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх зардал, энгийн хог хаягдлыг булшлах зардлыг батлагдсан тарифыг үндэслэн тооцож санхүүжүүлэх, орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ болон айл өрхийн хэрэглээнээс гарч байгаа хог хаягдлын нормативыг баталж, хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхийг Сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Хог хаягдлын хууль тогтоомжид заасны дагуу “Энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тариф”, тухайн нутаг дэвсгэрт мөрдөхөөр батлагдсан хог хаягдлын норматив, хог хаягдлын менежментийн хөтөлбөрт үндэслэн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг шинэчлэн батлахыг сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн 06 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.ОД-ЭРДЭНЭ

Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2024 оны 05 дугаар сарын 10 -ны
өдрийн дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

НИЙТИЙН ЭДЭЛБЭР ГАЗРЫН ХОГ ХАЯГДЛЫГ
ЦЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ

№	Ажлын нэр	Хэмжих нэгж /га/	Үнийн тариф /төгрөг/
1	Аймгийн нутаг дэвсгэрт мөрдөх нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх тариф	1	361,700.00

ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ БУЛШЛАХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ

№	Ажлын нэр	Хэмжих нэгж /тн/	Үнийн тариф /төгрөг/
1	Аймгийн нутаг дэвсгэрт мөрдөх энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тариф	1	31,129.21

Тайлбар: Цэвэрлэх, булшлах ажилд ашиглах машин техникийн марк, тухайн үеийн зах
зээлийн шатахууны үнэ ханшаас хамаарч тариф хэлбэлзэж болно: